

БАТЛАВ  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

*М. Манжсан*  
МОНХЗУЛ

ИЖ БҮРЭН СИЙЛБЭРТЭЙ ГЭР БОЛОН ГЭРИЙН  
ТАВИЛГА ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**Нэг. Зорилго**

Худалдан авах иж бүрэн гэр болон гэрийн тавилга нь Монгол үндэсний уламжлалт сийлбэр, хээ, угалзтай байх бөгөөд гадаад, дотоодын зочид төлөөлөгчдөд Монгол гэрийн онцлог, соёлын өвийг сурталчлан таниулахуйц байна.

**Хоёр. Худалдан авах бараа**

- Монгол үндэсний уламжлалт 8 ханатай гэр;
- 8 ханатай гэрийн тавилга (2 ш гэрийн иж бүрэн);
- 10 ханатай гэрийн тавилга;

**Гурав. Ерөнхий шаардлага**

- Гэрийн мод болон тавилгын мод нь нягтрал сайтай хуурай мод байна.
- Тооноо, унь, багана, хаалга нь цэвэр модны өнгөөрөө, өөр дээрээ ухмал сийлбэртэй, 2 давхар зориулалтын лакаар өнгөлсөн байна.
- Гэрийн тавилга (10 ханатай, 8 ханатай) бүр нь цэвэр модны өнгөөрөө, өөр дээрээ ухмал сийлбэртэй, 2 давхар зориулалтын лакаар өнгөлсөн байна.
- Сийлбэр нь Монгол хээ угалзны утга бэлгэдлийг тусгасан байна.
- Гэр болон гэрийн тавилга дээрх хээ угалз бэлгэдэл нь ямар нэгэн шашны агуулгагүй байна.

**Дөрөв. Худалдан авах барааны иж бүрдэл**

Д/Д	Иж бүрдэл нэр	Тоо хэмжээ	Тайлбар
<b>8 ханатай гэр</b>			
1	Тооно	1 ш	
2	Унь	1 ком	Унины сагалдаргыг малын гаралтай үс ноосоор хийсэн байна.
3	Багана	2 ш	
4	Хаалга	1 ш	
5	Хана	1 ком	Хар modoор хийсэн байна.
6	Өрх	1ш	
7	Гадуур бүрээс	1ш	Сайн чанарын цагаан бүрээс байх бөгөөд халзтай байна.
8	Дотуур цагаан бүрээс (цаваг)	1 ш	Дээвэр, туурга орсон бүтэн байна.
9	Хаяавч	1 ш	

10	Дээвэр туурга	1 ш	Гадна талын бороо усны хамгаалалттай, дунд хэсэгт нь зулхайтай, дотор хэсэг нь даавуун дотортой байна.
11	Дээвэр туурга	1 ком	Үйлдвэрийн цагаан эсгий дээвэр туурга байна.
12	Брезентэн дээвэр туурга	1 ком	Сайн чанарын ус нэвтэрдэггүй брезенттэй байна.
13	Бүслүүр (уяа, оосор)	1 ком	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрийн өрх, тоононы нь даруулга болон бэхэлгээний уянууд нь малын үс ноосоор сүлжиж томсон байна.</li> <li>- Бүслүүр болон бэхэлгээний уянуудыг сайн чанарын материалаар хийсэн байна.</li> </ul>
14	Шал	1 ш	
<b>10 ханатай гэрийн тавилга</b>			
1	Авдар	2 ш	10 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
2	Майга ширээ	4 ш	10 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
3	Хаан, хатан сэнтий	2 (тус бүр нэг, нэг)	10 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
4	Сандал	16 ш	10 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
5	Олбог	2 ш	Ширмэл цагаан эсгийн байна.
6	Тулга	1 ш	10 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
<b>8 ханатай гэрийн тавилга</b>			
1	Авдар	4 ш	8 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
2	Майга ширээ	6 ш	8 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
3	Сандал	16 ш	8 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.
4	Олбог	4 ш	Ширмэл цагаан эсгийн байна.
5	Тулга	2 ш	8 ханатай гэрийн стандартад нийцсэн байна.

---оо---